



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

Засгийн газрын VIII байр, Олимпийн гудамж 2,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210
Утас: (976-51) 26 36 95, Факс: (976-11) 32 35 41
Цахим шуудан: letter@moh.gov.mn
Цахим хуудас: www.moh.gov.mn

2026.04.21 № 10/1777

танай _____-ны № _____-т

Тайлан, зөвлөмж хүргүүлэх тухай

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 тушаалаар баталсан “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу танай байгууллагын 2025 оны үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Хавсралтаар хүргүүлж буй хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд тусгагдсан зөвлөмжийн дагуу үйл ажиллагааны үр дүнг сайжруулах чиглэлээр арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, зохион байгуулалтын холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн, тайланг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлнэ үү.

Хавсралт 5 хуудастай.

Хүндэтгэсэн,



Эрүүл мэндийн яам
Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ,
дотоод аудитын газрын дарга
Б.Янжмаа
2026.04.21 14:23

ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үндэслэл ба арга зүй

Эрүүл мэндийн байгууллагын 2025 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам”, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалаар баталсан “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д нийцүүлэн гүйцэтгэл, үр дүн, чанар, ил тод байдал, хэрэглэгчийн үнэлгээ зэрэг үндсэн шалгуур үзүүлэлтүүдэд үндэслэн иж бүрэн байдлаар гүйцэтгэв.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Эрүүл мэндийн яамны харьяа байгууллагуудын 2025 оны үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг бодитой тодорхойлон, илэрсэн сул талыг арилгах, сайжруулахад чиглэсэн тодорхой санал, зөвлөмж боловсруулах, улмаар байгууллагын үйл ажиллагаагаар дамжин иргэдэд хүрэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээ

Эмгэг судлалын үндэсний төвийн 2025 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээг дараах 5 чиглэлийн хүрээнд гүйцэтгэв. Үүнд:

1. Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт;
2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт;
3. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилт;
4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт;
5. Хэрэглэгчийн үнэлгээ.

3.1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт

Эмгэг судлалын үндэсний төв нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд нийт 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлийн дундаж 87.1 хувьтай байна.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зарим арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй түвшинд байгаа бөгөөд үүнд дараах арга хэмжээнүүд хамаарч байна:

- Эмгэг судлалын үндэсний төвийн 2024-2027 онд хэрэгжүүлэх “Стратеги төлөвлөгөө”-г боловсруулж батлуулна;
- Эмгэг судлалын дүрэм, бүтцийг шинэчлэн батлуулна;
- Санхүүгийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллах, шилэн данс хуулийн хэрэгжилтийг хангана.

3.2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2025 оны биелэлтийн үнэлгээ дунджаар 73.8 хувьтай байгаа нь зорилтот түвшинд хүрээгүй, хангалтгүй гүйцэтгэлтэй байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнд дараах зөрчил, дутагдал илэрсэн. Үүнд:

- Гадаад сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо зорилтот түвшинд хүрээгүй;
- Албан хаагчдын шилжилт хөдөлгөөн 30.4 хувьтай байгаа нь тогтоосон дээд түвшин (15%)-гээс давсан;
- Хоол унааны нэмэгдлийг 2021 оноос хойш нэмээгүй, 8,000 төгрөг байна. Энэхүү нэмэгдэл дээр зарим албан хаагчдад олгодог сүүний мөнгө болох 1,300 төгрөгийг нэмж тайлагнасан.
- Мөн Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалаар баталсан “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 7.3-т заасны дагуу тайлан, мэдээллийг хавсралт хүснэгт 3.6-ийн дагуу гаргаж ирүүлээгүй нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд тодорхой хүндрэл учруулсан.

Дээрх нөхцөл байдал нь байгууллагын хүний нөөцийн бодлого, сургалт хөгжлийн төлөвлөлт, хэрэгжилт хангалтгүй, мөн албан хаагчдын хоол, унааны нэмэгдэл зэрэг нийгмийн баталгааны хэрэгжилт хангалтгүй байгаатай холбоотойгоор ажилтны тогтвор суурьшил, сэтгэл ханамжид сөргөөр нөлөөлөх эрсдэл байгааг харуулж байна.

3.3. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ

Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны харьяа Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2025 оны жилийн эцсийн үнэлгээгээр тодорхойлсон бөгөөд нийт үнэлгээ 91.0 хувь байна.

Үзүүлэлт тус бүрээр авч үзвэл:

- Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал 96.0 хувьтай;
- Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал 100.0 хувьтай;
- Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал 76.0 хувьтай;
- Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал 100.0 хувьтай;
- Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал 97.0 хувьтай.

3.4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үнэлгээний дүн 63.8 хувь бөгөөд өмнөх оноос буурсан дараах үзүүлэлтүүд байна. Үүнд:

1. Задлан шинжилгээний хувь (үндэсний хэмжээнд);
2. Хүндрэлийн зөрүүний хувь (үндэсний хэмжээнд);
3. Судалгаа эрдэм шинжилгээний хүлээлгэн өгсөн тайлан;
4. Сэлгэн ажиллуулсан эмч, сувилагчийн тоо.

Анхаарах зүйлс: “Судалгаа, эрдэм шинжилгээний хүлээлгэн өгсөн тайлан” гэдэгт Шинжлэх ухаан, технологийн сан, Эрүүл мэндийг дэмжих сан болон гадаадын зээл, тусламжийн хүрээнд хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээр гүйцэтгэсэн бөгөөд тухайн байгууллагад албан ёсоор хүлээлгэн өгсөн тайланг хамааруулах тул энэхүү шалгуурт хамааралгүй судалгааг холбон оруулсан тохиолдолд тухайн үзүүлэлтийн үнэлгээг тэг оноогоор үнэлнэ.

Эрдмийн зэрэг хамгаалсан ажилтны тоонд боловсрол (магистр)-ын болон мэргэжлийн зэрэг хамгаалсан тохиолдлыг хамруулж ойлгохгүй.

Сэлгэн ажилласан гэдэгт байгууллагын даргын тушаалаар тодорхой хугацаанд хөдөө орон нутаг болон дүүргийн эмнэлэг, эрүүл мэндийн төвд томилогдон ажилласан мэргэжилтнүүдийг хамруулж ойлгох ба албан томилолтоор богино хугацаанд ажилласныг” сэлгэн ажилласан”-д тооцохгүй болно (Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийг үзнэ үү).

Иймд цаашид дээрх үзүүлэлтийг зөвхөн хөдөө орон нутаг болон дүүргийн эмнэлэг, эрүүл мэндийн төвд байгууллагын даргын тушаалаар тодорхой хугацаанд томилогдон ажилласан тохиолдлыг хамруулж, нэг мөр ойлголтоор тайлагнах шаардлагатай.

3.5. Хэрэглэгчийн үнэлгээ

2025 оны жилийн эцсийн байдлаар хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээ дунджаар 96.0 хувь буюу 4.8 оноотой байна.

Хэрэглэгчийн үнэлгээг 2025 онд хийхдээ байгууллагаас үйлчилгээ авсан нийт 65 үйлчлүүлэгчээс авсан үнэлгээнд үндэслэн, тэдгээрийн үнэлгээний арифметик дунджийг тооцох аргаар тодорхойлсон болно.

Дөрөв. Цаашид анхаарах асуудал, зөвлөмж

Байгууллагын 2025 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнд үндэслэн байгууллагын үйл ажиллагаанд илэрсэн системийн болон гүйцэтгэлийн шинжтэй доголдлыг арилгах, үйл ажиллагааны үр нөлөө, хариуцлага, ил тод байдал, чанарыг нэмэгдүүлэх зорилгоор дараах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэв. Үүнд:

1. Байгууллагын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог үр дүнд суурилсан менежментийн зарчимд нийцүүлэн боловсронгуй болгож, шийдвэр гаргалтын ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах, нэгж хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг бэхжүүлэх;

2. Гүйцэтгэлийн төлөвлөлтийг батлагдсан аргачлалын дагуу боловсруулж, суурь түвшин, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг тоон болон чанарын хувьд хэмжигдэхүйц, бодитой, харьцуулах боломжтой байдлаар тодорхойлж, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналын уялдаа холбоог бүрэн хангах;

3. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнг шалгуур үзүүлэлтэд тулгуурлан үнэлж, зорилтот түвшинд хүрсэн эсэхийг нотолгоонд суурилсан, нэгдсэн аргачлалтай, давхардалгүй, үнэн зөв тайлагнах тогтолцоог төлөвшүүлэх;

4. Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журам болон холбогдох арга зүйн баримт бичгийн хэрэгжилтийг бүрэн хангаж, төлөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, тайлагналын бүх үе шатанд арга зүйн нэгдмэл байдлыг мөрдөх;

5. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтийг бодит үр дүнд тулгуурлан үнэлэх, мөн төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хүрээнд хоол, унааны нэмэгдэл зэрэг цалин хөлсөөс бусад дэмжлэг, урамшууллын зохицуулалтыг өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдал, үнийн өсөлттэй уялдуулан үе шаттайгаар шинэчлэн тодорхойлж, хэрэгжилтийг тогтмол хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Түүнчлэн албан хаагчдыг урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамруулах ажлыг тогтмол болгон хэвшүүлэх;

6. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон холбогдох журам, стандартын хэрэгжилтийг хангаж, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, судалгаа, шинжилгээний мэдээллийг бүрэн, тогтмол, хүртээмжтэй, ойлгомжтой байдлаар олон нийтэд нээлттэй байршуулж, мэдээллийн ил тод байдлыг бодитоор нэмэгдүүлэх;

7. “Төрийн байгууллагын цахим хуудсанд тавигдах шаардлага MNS 6285:2017” стандартыг мөрдөж, байгууллагын цахим хуудсыг стандартын дагуу шинэчлэн хөгжүүлж, мэдээллийн бүтэц, хүртээмж, хэрэглэгчдэд ойлгомжтой байдлыг сайжруулах;

8. Цахим хуудсыг тогтмол ажиллагаатай байлгах, мэдээлэл байршуулах, шинэчлэх, хянах, хариуцлагажуулах асуудлыг хөдөлмөрийн дотоод журамд тусган мөрдүүлэх, мэдээллийн үнэн зөв, бүрэн байдал, цаг үеэ олсон байдлыг хангах дотоод хяналтын тогтолцоог бэхжүүлэх;

9. Албан хаагчдын хариуцлага, идэвх, санаачлагыг нэмэгдүүлэх зорилгоор гүйцэтгэлд суурилсан үнэлгээ, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгож, удирдлагын зүгээс хэрэгжүүлэх хяналт, хариуцлагын механизмыг чангатгах;

10. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор задлан шинжилгээний хувь болон хүндрэлийн зөрүүний үзүүлэлтийг сайжруулахад чиглэсэн зорилтот арга хэмжээг тусгайлан хэрэгжүүлэх;

11. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийг тайлагнахдаа үнэн зөв, нотолгоонд суурилсан мэдээлэл ашиглаж, үзүүлэлт тус бүрийн өөрчлөлтийн шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлон, тогтмол сайжруулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж хэвших.

Тав. Нэгдсэн үнэлгээ

Эмгэг судлалын үндэсний төвийн 2025 оны үйл ажиллагааны гүйцэтгэлд хийсэн нэгдсэн үнэлгээний дүнгээр нийт гүйцэтгэлийн хувь 80.5 хувьтай үнэлэгдсэн бөгөөд үнэлгээ нь байгууллагын үндсэн таван чиглэлийн үзүүлэлтэд тулгуурлан тооцогдсон байна. Үүнд: Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 87.1 хувь, Сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилт 73.8 хувь, Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үзүүлэлт 91.0 хувь, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлт 63.8 хувь, Хэрэглэгчийн үнэлгээ 96.0 хувь тус тус үнэлэгдсэн бөгөөд жингийн коэффициентээр жигнэн тооцоход нийт нэгдсэн үнэлгээ 80.5 хувьд хүрсэн байна.

Эдгээр үзүүлэлтээс харахад байгууллагын үйл ажиллагааны зарим чиглэлд гүйцэтгэл харьцангуй хангалттай байгаа боловч эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлт нь нийт үнэлгээнд сөргөөр нөлөөлсөн гол хүчин зүйл болж байна.

Иймд эдгээр чиглэлд гүйцэтгэлийн үр дүнг сайжруулах, шалтгаан, нөлөөлөгч хүчин зүйлсийг нарийвчлан тодорхойлох, зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үнэлгээний задаргааг Хүснэгт 1-т үзүүлэв.

Хүснэгт 1. 2025 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн нэгдсэн үнэлгээний задаргаа

№	Үзүүлэлт	Хэрэгжилтийн хувь	Жин	Оноо
1	Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	87.1	0.2	17.4
2	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт	73.8	0.15	11.1
3	Нээлттэй мэдээллийн ил тод байдлыг илтгэх үзүүлэлт	91.0	0.15	13.7
4	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлт	63.8	0.3	19.1
5	Хэрэглэгчийн үнэлгээ	96.0	0.2	19.2
Нэгдсэн үнэлгээний хувь			80.5	

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

2026 оны 04 дүгээр сар